

Төрийн нарийн бичгийн даргын
2022 оны 04 дүгээр сарын 12-ний өдрийн
5 дугаар тушаалын 2 дугаар хавсралт
5/15

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын 2021 оны 265 дугаар
тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 1 дүгээр сарын 12 ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Нэгжийн нэр:

Ерөнхий боловсролын бодлогын удирдлага,
зохицуулалтын газар

Албан тушаалын нэр:

Ерөнхий боловсролын бодлогын
удирдлага, зохицуулалтын
газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Эрхэлсэн түшмэл, Т3-13

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Бага, дунд боловсролын салбарын хөгжлийн бодлого, стратеги, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг удирдлагаар хангах, хэрэгжилт, гүйцэтгэл судалгаа, шинжилгээ хийх, салбарт нийтээр дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиг үүргийн хүрээнд ажлын гүйцэтгэл, үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн
165 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 1 дүгээр сарын 12 ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Нэгжийн нэр:

Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар

Албан тушаалын нэр:

Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Эрхэлсэн түшмэл, Т3-13

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр

Хөдөлмөрийн нэхцэл:

Хэвийн

Онцгой нэхцэл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Бага, дунд боловсролын салбарын хөгжлийн бодлого, стратеги, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг удирдлагаар хангах, хэрэгжилт, гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийх, салбарт нийтээр дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиг үүргийн хүрээнд ажлын гүйцэтгэл, үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, үнэлгээний бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг удирдлагаар хангах;
2. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын хүний нөөцийн чиглэлээр батлагдсан бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг удирдлагаар хангах;
3. Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг удирдлагаар хангах;
4. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургах бодлого хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;
5. Сургалтын байгууллага, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг удирдлагаар хангах;
6. Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
7. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг Үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр бодлого, хууль тогтоомжид заасан дүрэм, журам, заавар, аргачлал, шаардлага, богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, удирдамж, зөвлөмж зэрэг зохион байгуулалтын баримт бичгийг шинэчлэх, шинээр боловсруулах, баталгаажуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах; 2.Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтэд холбогдох судалгаа шинжилгээ хийх, шинэчлэх, өөрчлөлт оруулах санал бэлтгэх, батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг удирдлагаар хангах,	Сургалтын хөтөлбөр, үнэлгээний эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсон байна.	Ш,Х,Т
	3.Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт суурисан хичээлийн жилийн бүтцийг тогтоох,	Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ	Ш,Х,Т
		Бүтэц оновчтой батлагдсан байна.	Ш,Х,Т



	хэрэгжилтэд шинжилгээ хийх, шинэчлэх, өөрчлөх санал боловсруулах;		
4.	Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний төрөл, хэлбэр, үнэлгээний зорилт, шалгуурыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангах;	Сургалтын хөтөлбөрийн үнэлгээг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж гарсан байна.	Ш,Х,Т
5.	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн болон суралцагчийн үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багц цагийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг бодлогын удирдлагаар хангах	Үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт ойртуулсан байна	Ш,Х,Т
6.	Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөр, үнэлгээний чиглэлээр хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, багшийн арга зүйг хөгжүүлэх шинэ технологи, инновацыг сургалтад нэвтрүүлэх ажлыг бодлогын удирдамжаар хангах;	Сургуулийн удирдлага, багш нарын чадавх дээшилсэн байна.	Ш,Х,Т
7.	Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед сургалтын тасралтгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөх, олон улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй уялдуулан салбар дундын оролцоотой зохицуулалт хийх;	Сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээний чиглэл батлагдсан байна.	Ш,Х,Т
8.	Сургалтын хөтөлбөр, арга зүйн чиглэлээр эрдэм шинжилгээ арга зүйн байгууллага, дотоод, гадаадын зөвлөх үйлчилгээ, төсөл, хөтөлбөр боловсруулах ажлын хэрэгцээ, шаардлага, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах;	Боловсролын үйлчилгээний чанарт ахиц гарсан байна.	Ш,Х,Т
9.	Ерөнхий боловсролын сургалтын баримт бичгийн загвар, хөтлөх аргачлалыг олон улсын жишигт ойртуулан хөгжүүлэх, боловсролын баримт бичиг олгох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг удирдлагаар хангах;	Хүүхдийн суралцсан байдлын талаар мэдээллийн сан бүрдэж, эрхзүйн акт батлагдсан байна.	Ш,Х,Т
10.	Гадаад улсад ерөнхий боловсрол эзэмшсэн иргэдийн боловсролын баримт бичиг дүйцүүлэх, Монгол Улсын ерөнхий боловсролын сургуульд шилжин ирсэн иргэдийг ерөнхий боловсролд хамрагдах эрх зүйн	Эрх зүйн зохицуулалт оновчтой, тодорхой болсон байна.	Ш,Х,Т



	зохицуулалтыг боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.		
2 дугаар зорилтын хүрээнд	1. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн асуудлыг сайжруулах чиглэлээр богино хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээний удирдамжийн төсөл боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Судалгаанд үндэслэсэн, хөгжлийг дэмжсэн байна.	T, X, Ш
	2. Салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгааллын асуудлаар холбогдох хууль тогтоомжид заасан дүрэм, журам, заавар, аргачлал, шаардлага, чиглэл, тодорхойлолтын төслийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг удирдлагаар хангах;	Захиргааны хэм хэмжээ тогтоох акт нь Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцсэн байна.	T, Ш, Х
	3. Багш, удирдах болон мэргэжлийн бусад ажилтны ажлын агуулга, бүтэц, чиг үүрэг, албан тушаалын ангилал, зэрэглэл, нийгмийн асуудал, ажлын байрны нөхцөлд үнэлгээ хийх, үр дүнг бодлого, шийдвэрт тусгуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Нотолгоонд суурилсан шинжилгээний дүгнэлт, санал дэвшүүлсэн байна.	Ш, Т, Х
	4. Салбарын хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, багшийн нөөцийн ойрын болон дунд хугацааны судалгаа хийж, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх ажлыг бодлогын удирдлагаар хангах;	Мэдээллийн сан бүрдэж ашиглалт сайжирсан байна.	Ш, Т, Х
	5. Багш бэлтгэх мэргэжлийн чиглэл, нийгмийн хэрэгцээ, багшийн ажлын ачаалал, цалин хөлс, нийгмийн баталгаа, давтан бэлтгэх талаар гадаад улсын болон өөрийн орны түвшинд судалгаа хийж холбогдох эрх зүйн баримт бичгийг сайжруулах;	Багш бэлтгэх тогтолцоо, багшийн хангамжийн бодлого сайжирсан байна.	Ш, Т, Х
	6. Багшийн мэргэжлийн чиглэл, багш бэлтгэх, багшлах дадлага, багшийг давтан бэлтгэх арга хэмжээний төлөвлөгөөг олон улсын чиг хандлага, сургалтын арга зүй, технологийн хөгжил болон монгол орны онцлог, ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хэв шинжийг харгалзан оновчтой боловсруулах, батлах хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Багш бэлтгэх, давтан бэлтгэх тогтолцоо оновчтой болно.	Ш, Т, Х



	<p>7.Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах загвар боловсруулах, турших, багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны богино хугацааны төлөвлөлт хийх, багш, ажилтны мэргэжлийг дээшлүүлэх модульд суурилсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх ажлын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;</p>	<p>Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх тогтолцоо боловсронгуй болсон байна.</p>	Ш, Т, Х
	<p>8.Багш, ажилтны мэргэжлийн түвшин, ур чадвар, ажлын үр дүн, гүйцэтгэлд суурилсан үнэлгээний бодлогын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</p>	<p>Мэргэжил, арга зүйн удирдамжаар хангасан байна.</p>	Ш, Т, Х
	<p>9.Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллага хоорондын түншлэлийг хөгжүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;</p>	<p>Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх ажилд ахиц гарсан байна.</p>	Ш, Т, Х
	<p>10.Багш, мэргэжлийн ажилтан ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг сайжруулах чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, нөлөөллийн арга хэмжээний нэгдсэн төлөвлөлт хийх, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах.</p>	<p>Ёс зүйн зөрчил, авлига, ашиг сонирхлын асуудлыг шийдвэрлэсэн, зөрчил буурсан тоо, чанарт ахиц гарсан байна.</p>	Ш, Т, Х
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Сургалтын байгууллагын орчин дахь хүүхдийн эрх, хөгжил, төлөвшил, хамгааллын асуудлаар баримтлах бодлого, төлөвлөгөө, хууль, тогтоомжид заасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт, богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, удирдамж, зөвлөмжийн төсөл боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;</p>	<p>Хуульд заасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг батлуулсан байна.</p>	Ш, Т, Х
	<p>2.Сургалтын орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилтэд шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгцээ, тулгамдсан асуудлыг тодорхойлох, нөхцөл байдлыг үнэлэх, дүгнэлт гаргах, санал боловсруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг удирдлагаар хангах.</p>	<p>Холбогдох шинжилгээ, үнэлгээ хийгдэж, түүний мөрөөр арга хэмжээ авсан байна.</p>	Ш, Т, Х



	<p>3.Хичээлээс гадуурх сургалтын ажлын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, үнэлгээ хийх, чанар, хүртээмжийг сайжруулах санал, хувилбар боловсруулах, байгууллага хоорондын хамтын ажиллагааны сүлжээг хөгжүүлэх ажлыг төлөвлөх, удирдлагаар хангах;</p> <p>4.Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг уялдуулан, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;</p> <p>5.Сургалтын орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээрх сайн туршлагыг сурталчлах, зөвлөмж, гарын авлага боловсруулах ажлыг удирдлагаар хангах;</p> <p>6.Хүүхдийн оролцооны байгууллага болон хичээлээс гадуурх сургалтын ажлаар ХХI зууны иргэнд шаардагдах харилцааны суурь чадварыг хөгжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;</p> <p>7. Цахим орчны зохистой хэрэглээг бий болгох талаар хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, олон нийтийн оролцоотойгоор нөлөөллийн арга хэмжээг бүх түвшинд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг бодлогын удирдамжаар хангах.</p>	<p>Хичээлээс гадуурх сургалтын чанар, хүртээмж сайжирсан байна.</p> <p>Төсөл хөтөлбөрүүд харилцан уялдаатай ажиллаж, үр дүнд хүрсэн байна.</p> <p>Эцэг эх, асран хамгаалагчдын хандлагад өөрчлөлт гарсан байна.</p> <p>Хүүхдийн хөгжил, төлөвшил, нийгэмшихүйд ахиц гарна.</p> <p>Цахим хэрэглээний соёл бий болно</p>	Ш, Т, Х Ш, Т, Х Ш, Т, Х Ш, Т, Х Ш, Т, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Тэгш хамран сургах (хөгжлийн бэрхшээл, үндэстний цөөнх, хэл, соёл, хилийн чанад дахь монгол хүүхэд, сургууль завсардсан хүүхэд) асуудлаар холбогдох хууль тогтоомжид заасан дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохион байгуулалтаар хангах;</p> <p>2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн төвд хамруулахтай холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;</p>	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцсэн байна</p> <p>Хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнд хүрсэн байна</p>	Ш, Т, Х Ш, Т, Х

	3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, ажилтанд шаардлагатай эрх зүйн орчныг бий болгох, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Баримт нотолгоонд үндэслэсэн, тооцоо судалгаа гарсан, бодлогын зорилттой нийцсэн зохицуулалт хийгдсэн байна	Ш, Т, Х
	4. Хавсарсан бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдэд хүүхдэд боловсрол эзэмших, хөгжих нийгмийн үйлчилгээг бий болгох;	Салбар дундын зохицуулалтын хамрах хүрээ, нэгдмэл байдал бий болсон байна.	Ш, Х, Т
	5. Сургууль завсардсан иргэдэд бага, дунд боловсрол нөхөн олгох сургалтын модуль, платформыг хөгжүүлэх, тэдгээрийг нэвтрүүлэх ажлыг бодлогын удирдлагаар хангах;	Боловсрол нөхөн эзэмших үйлийг дэмжих платформ үйл ажиллагаанд нэвтэрсэн байна.	Ш, Х, Т
	6. Хөгжлийн бэрхшээл, нийгмийн болон хэл, соёлын ялгаатай хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургах асуудлаар бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, сайжруулах санал хувилбар дэвшүүлэх, хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Хэрэгжилтийг хууль тогтоомжид нийцүүлсэн байна.	Ш, Х, Т
	7. Тэгш хамран сургалтын агуулга, хөтөлбөр, үнэлгээний арга зүйг боловсруулах, багшийг арга зүйгээр хангах ажлыг бодлогын удирдлагаар хангах зохион байгуулах;	Судалгаанд үндэслэсэн, бодлогын зорилттой нийцсэн байна	Ш, Т, Х
	8. Нийт суралцагчдын дийлэнх олонх нь үндэсний цөөнхийн иргэдийн хүүхэд суралцдаг сургуульд хос хэлний сургалтын арга зүйг нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах, батлуулах;	Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болсон байна.	Ш, Х, Т
	9. Иргэдэд бага, дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх, амьдрах ухаан, бичиг үсгийн чадвар эзэмшүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Бага, дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх эрхзүйн зохицуулалтыг хангасан байна.	Ш, Х, Т



	10. Тэгш хамран сургах чиглэлээр хэрэгжиж буй гадаад/дотоодын төсөл, хөтөлбөрийн ажлыг уялдуулах, салбар дундын болон нийгмийн түншлэлийг бэхжүүлэх үйл ажиллагааг зохицуулалтаар хангах.	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангасан байна	Ш,Х,Т
5 дугаар зорилтын хүрээнд	1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага болон сургалтын орчин, хэрэглэгдэхүүний асуудлаар холбогдох хууль тогтоомжид заасан дүрэм, журам, заавар, аргачлал, зөвлөмж, стандарт шаардлага, норм, норматив, богино хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж, чиглэл, зөвлөмж боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохион байгуулалтаар хангах;	Хэрэгжилтийг хууль тогтоомжид нийцүүлсэн байна.	Ш,Т, Х
	2. Сургалтын байгууллагын бүтэц, байршил, хэв шинжийг оновчтой тогтоох чиглэл, хүн ам болон орон нутгийн онцлогт нийцүүлэн улсын хэмжээнд сургуулийн зураглал хийх зөвлөмж, аргачлал боловсруулах хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гарах, нөөцийг оновчтой хуваарилах нөхцөл бүрдэнэ.	Ш,Х,Т
	3. Сургуулийн бие даасан байдлыг хангах, олон нийтийн оролцоот сургуулийн загвар боловсруулах, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах	Сургууль бие даан хөгжихэд дэмжлэг болно	Ш,Х,Т
	4. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын бүтэц, орон тоог боловсронгуй болгох, албан тушаалтны ажлын чиг үүргийн уялдааг хангах, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлын төлөвлөлт хийх, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Орон нутгийн боловсролын мэргэжлийн байгууллагын чадавх, үйлчилгээний чанарт ахиц гарахад дэмжлэг болно.	Ш,Т, Х
	5. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагыг хөгжүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, хүний нөөцийг давтан бэлтгэх тогтолцоо бүрдүүлэх талаар богино хугацаанд авах арга хэмжээний	Орон нутгийн боловсролын байгууллагын үйлчилгээний чанарт ахиц гарахад дэмжлэг болно.	Ш,Х,Т



	төлөвлөгөө хийх, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;		
	6.Сурах бичиг зохиох, хэвлэн түгээх, сургалтад цахим технологи, хэрэглэгдэхүүн ашиглахтай холбогдох харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлагаар хангах;	Сурах бичгээр хангагдсан байна.	Ш,Т, Х
	7.Гадаадын хөрөнгө оруулалттай болон олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургууль байгуулах, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг зохион байгуулах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Ш,Х,Т
	8.Орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын хэрэгжилт, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн хангамж, хүртээмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, цаашид авах хариу арга хэмжээний санал, хувилбар боловсруулах.	Дүн шинжилгээ хийж, зөвлөмж, мэдээллээр хангасан байна.	Ш,Т, Х
6 дугаар зорилтын хүрээнд	1.Суралцагчийн хоол үйлдвэрлэл, хүнсний үйлчилгээний чиглэлээр дунд, урт хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон нийтлэг харилцааг зохицуулах дүрэм, журмын хэрэгжилтэд шинжилгээ хийх, шинэчлэн болон шинээр боловсруулах, батлуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах;	Бодлого, хууль тогтоомжийн эрхэйн зохицуулалт бүрдсэн байна.	Ш,Х,Т
	2.Суралцагчийн хоол үйлдвэрлэл, хүнсний үйлчилгээний чиглэлээр богино хугацааны төлөвлөлт, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг удирдлагаар хангах;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцсэн байна.	Ш,Т, Х



	<p>3.Хүүхдийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, суралцагчийн хоол, хүнсний эрүүл ахуй, илчлэг, норм, нормативыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг удирдлагаар хангах;</p>	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцсэн байна.</p>	Ш,Х,Т
	<p>4.Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүний нөөцийн бэлтгэх, давтан сургах, хэтийн төлөвийг тооцох, менежментийн шийдэл хувилбарыг боловсруулж, хэрэгжилтийг зохицуулалтаар хангах;</p>	<p>Хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоо бурдсэн байна</p>	Ш,Т, Х
	<p>5.Гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр урт, дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах;</p>	<p>Судалгаанд үндэслэсэн, хүрэх үр дүнг тодорхойлсон, гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцсон байна.</p>	Ш,Х,Т
	<p>6.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, гадаадын зээл, тусlamж, хөрөнгө оруулалтын үндсэн чиглэлд цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлаар тусгах зорилт, арга хэмжээний санал боловсруулах;</p>	<p>Асуудлыг бүрэн хамруулж, оновчтой томьёолон, төлөвлөлтөд тавих шаардлагыг бүрэн хангасан байна.</p>	Ш,Т, Х
7дугаар зорилтын хүрээнд	<p>1.Газрын болон харьяалах хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, биелэлтийг тооцох ажлыг удирдлага, чиглэлээр хангах;</p>	<p>Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.</p>	Ш,Х,Т, Г
	<p>2.Нэгжийн стратеги, чиг үүрэгтэй холбоотой бодлого, хууль, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг удирдлагаар хангах;</p>	<p>Биелэлтийг чанартай, шуурхай тайлагнасан байна.</p>	Ш,Т, Х
	<p>3.Удирдах албан тушаалтан, холбогдох байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;</p>	<p>Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.</p>	Ш,Т, Х, Г



	4. Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлагын дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө чиглэлээр хангах, хамтран ажиллах	Нэгжийн үйл ажиллагааны үр дүнтэй хэрэгжсэн байна.	Ш, Т, Х, Г
	5. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж нэгжийн эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг "Хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Ш, Х, Т
	6. Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх.	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Ш, Т, Х
	7. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, төрийн албаны хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах.	ХОМ хугацаанд нь мэдүүлж, ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	- Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	- Боловсрол /011/, Багш, мэргэжлийн /0114/, менежмент ба удирдахуй /041301-141303/	
Мэргэшил	- Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	
Туршлага	- Төрийн албанад 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын салбарын бодлогын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах; - нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; - салбарын эрсдэлийн удирдлагын бодлогод суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах; - бага, суурь, бүрэн дунд боловсролын салбарын бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих; - бусад



	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого, стратегийг бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах; - салбарын үйл ажиллагаан дахь эрсдэлийг урьдчилан тодорхойлох, илрүүлэх, шинжлэн дүгнэх, авах арга хэмжээний хувилбар боловсруулах; - салбарыг хөгжүүлэх талаар хэлэлцүүлэг, хурал, семинарыг удирдан зохион байгуулах, чиглүүлэх, оновчтой санал, дүгнэлт гаргах; - бусдын саналыг сонсох, саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - дүрэм, журмын төсөл боловсруулахад харьяа байгууллага, судлаачдыг оролцуулах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах; - салбарын үйл ажиллагааны чиглэлээр хэлэлцүүлэг, хурал, семинарыг удирдан зохион байгуулах, чиглүүлэх, оновчтой санал, дүгнэлт гаргах; - салбарын үйлчилгээнд учирч болзошгүй эрсдлийг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - бусад
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарын зэрэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль тогтоомжийн төсөлд тусгах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг харгалзdag байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх; - шинэлэг санаа дэвшилтэт арга барил, үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачлага, бүтээлч сэтгэлгээ, хандлагыг дэмжих; - шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - харилцааны өндөр соёлтой байх; - зөрчилдөөнийг эв дүйгээр зохицуулах; - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - нээлттэй, шударга байх; - ажлын шинэ арга барилыг нэвтрүүлж, хөгжүүлэх, бүтээлч, санаачлагатай ажиллах; - нэгжийн зорилтыг тодорхойлоходоо хамт олны оролцоог хангах, санал авах, тусгах; - өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайллан удирдах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг

		<p>байх;</p> <ul style="list-style-type: none"> - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд таниулах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйтээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - компььютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - жендэрийн тэгш байдлыг хангах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Төрийн нарийн бичгийн дарга


<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>
<p>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <ul style="list-style-type: none"> - хэлтсийн дарга -2 - ахлах шинжээч- 2 - шинжээч -4 - ахлах мэргэжилтэн – 4 <p>нийт-12</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс; - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан; - Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:



<p><u>Албан тушаал:</u></p> <p>АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ  /Б.ГАНТУЛГА/ (Гарын үсэг)</p> <p>2022 оны 01 дугаар сарын 01-ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр:</p> <p>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 22.03.30</p> <p>Дугаар: 165</p>
<p>Албан тушаалын тодорхойлолт баталсан:</p> <p><u>Байгууллагын нэр:</u></p> <p>БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u> 2022. 04. 01</p> <p>Дугаар: 5/25 (тамга/ тэмдэг) ТӨРИЙН НАРИИН БИЧИЙН ДАРГА  (Гарын үсэг)</p> <p>2022 оны 01 дугаар сарын 01-ны өдөр</p>	
<p>/Л.ЦЭДЭВСҮРЭН/ (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p>	

